



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нийцлийн аудитын тайлан

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт



**Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт
өмнөх оноос 9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.**

2017 он

АГУУЛГА

<u>Тайланг бэлтгэсэн:</u> Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар Дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа Аудитын менежер Г.Наранбаяр 2017 оны 10-11 дүгээр сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7054-3151 дугаарын утас, 7054-3179 дугаарын факсаар харилцана уу. ХАЯГ: Аймгийн Засаг даргын тамгын газрын байр, 2 давхар, 217 тоот	Товчилсон үгийн тайлбар4 Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....5 Бүлэг 1. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1, 3.2-т заасан байгууллагуудаас нийт 8 байгууллага, сан шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цэс нээлгээгүй байна. 1.1. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд бүрэн хамрагдаагүй, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бие даасан цэс нээлгээгүй байна. 1.2. Байгууллагуудын шилэн дансны цахим хуудас, мэдээллийн самбар нь хуулийн 5 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна. Бүлэг 2. Шилэн дансны мэдээллийг дутуу байршуулсан, байршуулсан нийт мэдээллийн 33% нь хугацаа хоцорсон төлөвтэй байна. 2. 2.1. Хуулийн үйлчлэлд хамаарах нийт 52 байгууллага Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан мэдээллийг дутуу мэдээлж, 1 байгууллага огт мэдээлэл байршуулаагүй байна. 2.2. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын 31.0 хувь нь шаардлагатай мэдээллийг бүрэн оруулж, 68.0 хувь нь алдаатай буюу дутуу оруулсан бол 1.0 хувь нь цэс нээлгэсэн боловч огт мэдээлэл байршуулаагүй байна. 2.3. 2.4. Шилэн дансны тухай хуулийн 3.1.3-д хамаарах “Шивээ овоо” ХК нь хуулийн 6 дугаар зүйлийн 6.8-д заасан мэдээллийг нөхөн мэдээлснээс нийт оруулсан мэдээллийн 70.1 хувь нь хугацаа хоцорсон төлөвтэй байна. 2.5. Шилэн дансны тухай хуулийн 3.1.5-д хамаарах хувийн цэцэрлэгүүд нь хуулийн 6 дугаар зүйлийн 6.9-д заасан мэдээллийг байршуулсан байна.
---	--

	Бүлэг 3. Төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй байна. 3.1. Аймаг, сумдын ИТХ, багийн ИНХ-аас хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. 3.2. Хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасан этгээд хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна. 3.3. Хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т заасны дагуу үр дүнгийн гэрээнд хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай тусгасан байна. 3.4. Хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу аймгийн хэмжээнд иргэдээс ямар нэгэн гомдол, мэдээлэл, хүсэлт ирүүлээгүй байна. Бүлэг 4. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна. 4.1. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажилласан байна. 4.2. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжилт 100.0 хувьтай байна. Дүгнэлт..... Зөвлөмж.....
--	--

Товчилсон үгийн тайлбар

ҮАГ	Үндэсний аудитын газар
НАГ	Нийцлийн аудитын газар
ГСА	Говьсүмбэр аймаг
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот, байгуулалтын газар
НХҮХ	Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс
СХС	Сум хөгжүүлэх сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨҮААГ	Орон нутгийн өмчит үйлдвэр, аж ахуйн газар
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
НДС	Нийгмийн даатгалын сан
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ТЕГ	Тагнуулын ерөнхий газар
ИНХ	Иргэдийн нийтийн хурал

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Монгол Улсын Ерөнхий аудитор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газраас 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

2. Аудитын зорилт:

Аймгийн төрийн болон улс, орон нутгийн өмчит байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулан дүнг УАГ-ын НАГ-т болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгуулах, давтан гаргуулахгүй байхад аудитын зорилго чиглэгдлээ.

3. Аудитын хамарсан хүрээ:

Аудитад Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан хуулийн этгээд, байгууллага, албан тушаалтны 2016 оны 10 дугаар сарын 01-нээс 2017 оны 09 дүгээр сарын 30-ныг хүртэлх үйл ажиллагааг хамруулав.

4. Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөр, АДБОУС 100-400, 4200, Төрийн хяналт шалгалтын стандартыг баримтлан аудитын арга зүйн дагуу Шилэн дансны тухай хуулийн 3, 8 дугаар зүйлд заасан байгууллага, аж ахуй нэгжийн нэгдсэн болон өөрийн цахим хуудас, мэдээллийн самбарт байрлуулсан мэдээллийг, төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналтын хэрэгжилтийн тайлан, дансны хуулгын дүн, анхан шатны баримттай тулгах, санхүүгийн мэдээллийн самбарыг бодит байдал дээр нь очиж үзэх зэрэг аудитын горимуудыг ашиглалаа.

5. Аудитын багийн бүрэлдэхүүн:

Аудитыг дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа хянан удирдаж, аудитын менежер Г.Наранбаяр төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

6. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл

Аудитын тайлан нь оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, холбогдох байгууллагын санал, түүнд хийсэн тайлбар, хавсралт гэсэн бүтцээр үндсэн зорилтын дагуу бичигдсэн.

7. Үндсэн мэдээлэл:

Аймгийн хэмжээнд улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа, ил тод, нээлттэй ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх зорилго бүхий Шилэн дансны тухай хууль 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн бөгөөд 2016 оны 03 дугаар улирлын байдлаар Нийцлийн аудит хийгдсэн байна.

Аудитын батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан аудитын зорилт, дэд зорилтуудын дагуу Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2, 3.1.3-т заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн хамрагдаж байгаа, тэдгээр нь хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг бүрэн мэдээлж байгаа, 8 дугаар зүйлийн 8.2-т заасан байгууллага, албан тушаалтан хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж байгаа эсэхийг аудитаар онцгойлон анхаарч үзлээ.

Аудитад Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан улсын төсвийн 20, аймгийн ТЕЗ, түүний харьяа 68, нийт 89 төрийн болон орон нутгийн төсөвт албан газар, төсөл, хөтөлбөр, сан, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, компани, тэдгээрийн өмчийн оролцоотой байгууллагыг хамруулав.

2016 оны 3 дугаар улиралд хийгдсэн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 82 хувьтай байсан бол 2017 оны 09 дүгээр сарын 30-ны байдлаар аудитад 89 байгууллага хамрагдан 91.0 хувьтай хэрэгжүүлж, өмнөх аудитын гүйцэтгэлтэй харьцуулахад 9.0 хувиар өссөн байна.

Аймгийн хэмжээнд нийт 89 хуулийн этгээд, байгууллага шилэн дансны цахим хуудсанд бие даасан цэс нээлгэж, мэдээллээ байршуулахаас 81 хуулийн этгээд, байгууллага цэс нээлгэсэн байна.

Аймгийн хэмжээний байгууллага өмнөх оноос 4-өөр буурсан нь байгууллагуудын бүтцийн өөрчлөлттэй холбоотой байна.

Өмнөх оны шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар Шилэн дансны цахим хуудсанд бие даасан цэс нээлгээгүй байсан дор дурдсан байгууллагууд бие даасан цэсээ нээлгэсэн ба Сүмбэр сумын 2 сангийн цэсийг устгуулан тус сумын ОНХС-д нэгтгэсэн байна. Тухайлбал, Шивээговь, Баянтал сумдын Сум хөгжүүлэх, Байгаль хамгаалах, Мал хамгаалах сангууд цэс нээлгэн холбогдох мэдээллүүдийг байршуулсан бол Сүмбэр сумын ИТХ-ын тогтоолоор Сүмбэр сумын ОНХС-д Байгаль хамгаалах сан болон Мал хамгаалах сангуудын дансыг нэгтгэж тус 2 сангийн цэсийг устгуулсан байна.

Аймгийн болон сумдын ИТХ-аас Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу шилэн дансны үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан талаарх ажлын тайлан, мэдээлэл ирүүлээгүй байна.

Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд бүрэн хамрагдаж, мэдээлэл хүргэх хэлбэрийг баримталсан эсэх

Бүлэг 1

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1, 3.2-т заасан байгууллагуудаас нийт 8 байгууллага, сан шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цэс нээлгээгүй байна.

1.1. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд бүрэн хамрагдаагүй, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бие даасан цэс нээлгээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийж буй Нийцлийн аудитаар аймгийн хэмжээнд улсын болон орон нутгийн өмчит нийт 89 байгууллага, сан, төсөл хөтөлбөрүүдийг хамруулан шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нийт 87 цэс нээгдсэн нь давхардсан болон татан буугдсан байгууллагуудын 6 цэсийг хасуулаагүйтэй холбоотой байна. Үүнд: улсын төсвийн 19, орон нутгийн төсвийн болон тусгай шилжүүлгийн 35, төрийн өмчит 3, орон нутгийн өмчит 5, орон нутгийн болон Засгийн газрын тусгай сан 15, хувийн 4 цэцэрлэг байгаа бөгөөд илүү буюу татан буугдсан, нэгтгэсэн байгууллагуудын нийт 6 цэсийг хасуулаагүй байна.

Аймгийн хэмжээнд шилэн дансны цэс нээлгээгүй нийт 8 байгууллага, сан байгаагаас Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т хамаарч байгаа дараах 3 төсөвт байгууллага, сан, Төрийн өмчит 5 хувьцаат компанийн орон нутаг дахь салбарууд тус тус шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бие даасан цэс нээлгээгүй байна. Үүнд: аймгийн Тагнуулын тасаг, Цахилгаан дамжуулах сүлжээ, Цахилгаан түгээх сүлжээ, Монголын цахилгаан холбоо, Мэдээлэл харилцаа холбоо, Шуудан үйлчилгээний газар, аймгийн Засаг даргын нөөц сан, Эрчим хүчний зохицуулах зөвлөл тус тус цэс нээлгээгүй байна.

Харин Сүмбэр сумын ИТХ-ын тогтоолоор тус сумын Байгаль хамгаалах сан, Мал хамгаалах сангийн дансдыг хаан ОНХС дансанд нэгтгэсэн бөгөөд уг сангуудын Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд дахь цэсийг татан буугдсан байгууллага хэсэгт оруулсан байна.

Говьсүмбэр аймаг дахь Тагнуулын тасаг нь нууцын зэрэглэлтэй, мөн 2016 оноос ТЕГ-т нэгтгэн мэдээлж байгаа гэсэн шалтгаанаар цэс нээлгээгүй байна.

Зарим байгууллага, санг нэгтгэсэн боловч Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цэсийг татан буугдсан байгууллага хэсэгт шилжүүлээгүй, мөн илүү нээгдсэн цэсийг устгуулаагүй байна. Үүнд:

1. Говьсүмбэр аймаг цэсний харъяа байгууллагууд хэсэгт Сум хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах сан гэсэн 2 цэс илүү
2. Говьсүмбэр аймгийн Сүмбэр сум хэсэгт “Өрхийн эрүүл мэндийн газар” гэсэн цэс илүү нээгдсэн
3. Насан туршийн боловсролын төвийг татан буулгаж Сүмбэр сумын 1 дүгээр сургуульд шилжүүлсэн боловч цэсийг шилжүүлээгүй
4. Говьсүмбэр аймаг дахь Улсын нөөцийн салбарыг нь 2017 оны 5 сараас аймгийн Онцгой байдлын газартай нэгтгэсэн боловч татан буугдсан байгууллага хэсэгт шилжүүлээгүй
5. 2016 онд Хөдөлмөрийн хэлтэс, Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийг нэгтгэн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар байгуулан шинээр цэс нээлгэн мэдээллийг оруулж байгаа боловч НХҮХ-ийн цэсийг татан буугдсан хэсэгт мөн шилжүүлээгүй байна.

Иймд дээрх илүү нээгдсэн цэсийг устгуулах болон татан буугдсан байгууллага хэсэгт оруулах талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.

Дээрх байгууллагууд нь Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-т “Шилэн дансны бие даасан цэстэй байх” гэснийг тус тус зөрчиж байгаа боловч уг хуулинд салбар байгууллага тус бүрээр шилэн дансны цахим хуудсанд цэс нээх эсвэл, нэгтгэж мэдээлэх талаар тодорхойгүй байна.

1.2. Байгууллагуудын шилэн дансны цахим хуудас, мэдээллийн самбар нь хуулийн 5 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

Аймгийн хэмжээнд бүх байгууллагууд Шилэн дансны тухай хууль болон Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дагуу мэдээллийн самбар ажиллуулж байна. Тухайлбал, санхүүгийн тайлангийн дүгнэлт, сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг тухай бүр байршуулж хэвшсэн байна.

Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд шилэн дансны мэдээллийг бүрэн мэдээлж байгаа эсэх

Бүлэг 2

Шилэн дансны мэдээллийг дутуу байршуулсан, байршуулсан нийт мэдээллийн 33% нь хугацаа хоцорсон төлөвтэй байна.

2.1. Хуулийн үйлчлэлд хамаарах нийт 54 байгууллага Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан мэдээллийг дутуу мэдээлж, 1 байгууллага огт мэдээлэл байршуулаагүй байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д тухайн жилийн төсвийг мэдээлвэл зохих 74 байгууллагаас 73 байгууллага буюу 98.6 хувь, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг мэдээлвэл зохих 74 байгууллагаас 73 байгууллага буюу 98.6 хувь, орон

нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг мэдээлвэл зохих 6 байгууллага 100.0 хувь тус тус мэдээлсэн байна.

Тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө зэргийг Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс, Газрын харилцаа, барилга хот, байгуулалтын газар тус тус мэдээллээгүй байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-д заасан 01-10 дугаар сарын гүйцэтгэлийг 65 байгууллага буюу 92.7 хувь нь бүрэн мэдээлсэн, 4 байгууллага шинээр байгуулагдсан болон бүтэц өөрчлөгдсөнтэй холбоотойгоор 1-2 сарын мэдээллийг дутуу байршуулсан байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-д зааснаар дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор мэдээлвэл зохих 74 байгууллагаас 94.4 хувь буюу 68 байгууллага мэдээлж, 6 төсөвт байгууллага мэдээллээгүй байна. Тухайлбал, Шүүхийн тамгын газар, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, 5 дугаар сургууль, 4-р цэцэрлэг, Баянтал сумын Соёлын төв гэсэн 6 байгууллага дараа жилийн төсвийн төслийг мэдээллээгүй байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-д зааснаар эхний хагас жилийн санхүүгийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор мэдээлвэл зохих 74 байгууллагаас 72 байгууллага буюу 97.3 хувь мэдээлсэн бол Сүмбэр сумын ИТХ, Шивээговь сумын ИТХ гэсэн 2 байгууллага мэдээллээгүй байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-д заасан жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, 6.1.5-д төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор мэдээлвэл зохих 75 байгууллагаас 71 байгууллага буюу 94.6 хувь мэдээлжээ.

Жилийн эцсийн санхүүгийн тайланг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Нийгмийн даатгалын сан, Ахмадын хороо, аудитын дүгнэлтийг аймгийн аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Баянтал сумын ЗДТГ, Нийгмийн даатгалын сан тус тус мэдээллээгүй байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5-д заасан аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор мэдээлвэл зохих 74 байгууллагаас 69 байгууллага буюу 93.2 хувь мэдээлсэн байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6-д зааснаар төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр мэдээлвэл зохих 74 байгууллагаас 74 байгууллага буюу 100.0 хувь мэдээлсэн байна. Хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.5-д зааснаар

Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтыг улирал бүр мэдээлвэл зохих мэдээллийг 100.0 хувь мэдээлсэн байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.8-д зааснаар Тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтыг улирал бүр мэдээлвэл зохих 15 сан 100.0 хувь мэдээлсэн байна. Хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.9-д Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг улирал бүр мэдээлвэл зохих 4 сан 100.0 хувь мэдээлсэн байна.

Дээрх зөрчлүүд нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.1.1, 6.1.3, 6.1.4 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд холбогдох мэдээллийг дутуу байршуулсан байгууллагуудын хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ. Шивээговь сумын ИТХ, ЗДТГ-ын нягтлан бодогчид аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны шалгалтаар хариуцлага тооцогдсон байна.

Дээрх зөрчлүүд нь байгууллагуудын шилэн данс хариуцсан ажилтнууд шилэн дансанд холбогдох мэдээллийг оруулахдаа нэгдсэн цахим хуудас дахь маягтыг бүрэн бөглөх шаардлагатай боловч байгууллагын үйл ажиллагаатай холбогдолгүй гэсэн хайхрамжгүй үйлдлээс мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулаагүйтэй холбоотой байна.

2.2. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын 32.0 хувь нь шаардлагатай мэдээллийг бүрэн оруулж, 67.0 хувь нь алдаатай буюу дутуу оруулсан бол 1.0 хувь нь цэс нээлгэсэн боловч огт мэдээлэл байршуулаагүй байна.

Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд улирлан тайлангаа 2016 онд бүрэн илгээгээгүй байсан бол 2017 оны 03 дугаар улирлын тайланг 100 хувь илгээсэн байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д зааснаар тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, 6.4.2-т зааснаар тухайн байгууллагын төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт, 6.4.3-т Тендер, худалдан авалттай холбоотой мэдээллүүдийг мэдээлвэл зохих 76 байгууллагаас 75 байгууллага буюу 98.7 хувь нь мэдээлсэн байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-д зааснаар таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээллийг мэдээлвэл зохих 74 байгууллага 5,144.9 сая төгрөгийн 367 гүйлгээг мэдээлсэн боловч 45.9 сая төгрөгийн 15 гүйлгээг дутуу мэдээлсэн байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д зааснаар Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг мэдээлвэл зохих 74 байгууллага 13,517.0 сая төгрөгийн 1089 гүйлгээг мэдээлсэн бол 7 байгууллага 188.3 сая төгрөгийн 118 гүйлгээг мэдээллээгүй байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д зааснаар таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээг мэдээлвэл зохих 75 байгууллага 7,564.8 сая төгрөгийн 298 гүйлгээг мэдээлсэн боловч Боржигин чуулга болон “Илчлэг-Шивээ” ОНӨҮГ нийт 219.6 сая төгрөгийн 55 гүйлгээг дутуу мэдээлсэн байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.6-д заасан Худалдан авалтын аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн болон 6.4.7-д заасан байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт зэргийг мэдээлвэл зохих 76 байгууллагын 75 буюу 98.7 хувь нь мэдээлсэн байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасан Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг мэдээлвэл зохих 76 байгууллагаас 75 байгууллага буюу 98.7 хувь нь 307,0 сая төгрөгийн 86 шийдвэрийг мэдээлсэн боловч 3 байгууллага 70.5 сая төгрөгийн 54 шийдвэрийг мэдээлээгүй байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.9-д Хууль тогтоомжид заасан бусад мэдээллийг мэдээлвэл зохих 76 байгууллагаас 75 байгууллага буюу 98.7 хувийн биелэлтэй мэдээлсэн байна.

Шилэн дансны дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.4-т заасан мэдээллүүдийг хэрхэн мэдээлэх талаар зөрүүтэй ойлголттой байгаагаас цалингийн зардлаас бусад таван сая төгрөгнөөс дээш орлого, зарлагын мөнгөн гүйлгээ хэсэгт зарим байгууллага санхүүжилтийн орлогыг мэдээлсэн бол зарим нь огт мэдээлээгүй байна.

Зарим байгууллагууд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8- заасан мэдээллийг дутуу байршуулснаас нийт 524.3 сая төгрөгийн ажил гүйлгээг дутуу мэдээлсэн байна.


Мэдээллээ дутуу байршуулсан байгууллагуудын судалгааг хүснэгтээр харуулбал:

Д/д	Байгууллагын нэр	/сая төгрөгөөр/		
		Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ	Хөрөнгө зарцуулах тушаал шийдвэр	5 сая төгрөгөөс дээш зарлагын гүйлгээ
1	Аймгийн ИТХ		2,1	18,4

2	Аймгийн ЗДТГ	54,3	81,5	
3	Баянтал сумын 4-р цэцэрлэг			14,8
4	Боржигин чуулга	51,0	10,2	
5	ГХБХБГ		7,4	
6	Сүмбэр сумын 5-р цэцэрлэг		50,4	
7	Баянтал сумын 4-р сургууль	14,1	14,1	31,1
8	Баянтал сумын Соёлын төв		6,3	
9	Илчлэг-Шивээ ОНӨААТҮГ	203,6		
Нийт дүн		219,6	70,5	188,3
			524,3	45,9

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бие даасан цэс нээсэн байгууллагын мэдээлэл оруулсан байдлыг диаграмаар харуулбал:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цэс нээлгэсэн байгууллагуудын мэдээлэл оруулсан байдал /тоо, хувиар/




Диаграмаас харахад нийт 81 цэс нээлгэснээс 32.0 хувь буюу 25 байгууллага мэдээллээ бүрэн оруулж, 67.0 хувь буюу 54 байгууллага мэдээллийг алдаатай буюу дутуу оруулсан бол 1.0 хувь буюу 1 байгууллага огт мэдээлэл байршуулаагүй байна.

Орон нутгийн зарим байгууллага, хуулийн этгээдүүд Шилэн дансны тухай хуульд заасан хугацаанд нь мэдээллээ байршуулаагүй байна.

Холбогдох мэдээллийг байршуулсан хугацааг диаграмаар харуулбал:

Холбогдох мэдээллийг хугацаанд нь оруулсан байдал



Диаграмаас харахад нийт байршуулсан мэдээллийг 33.0 хувь нь хугацаа хоцорсон төлөвтэй байна.

Байгууллагууд Шилэн дансны хуулийн дагуу Шилэнд дансны цахим хуудсанд холбогдох мэдээллийг байршуулахдаа дараах алдаа, зөрчлийг гаргасан байна. Үүнд:

- Хөрөнгө зарцуулах болон тэтгэмж олгосон тушаал, шийдвэрийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн мэдээлээгүй, зарим байгууллага эрх бүхий албан тушаалтны шийдвэрийн мэдээлэл оруулсан боловч уг шийдвэрийг файлаар байршуулаагүй,
- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний хэсэгт ихэнх байгууллагууд холбогдох мэдээллийг дутуу оруулсан бөгөөд өссөн дүнгээр оруулах байтал тухайн сард гарсан 5,000.0 мянган төгрөгнөөс дээш үнийн дүнтэй гүйлгээний мэдээлэл оруулсан,
- Мөн таван сая төгрөгнөөс дээш үнийн дүнтэй худалдан авалтыг мэдээлэх хэсэгт зардлыг өссөн дүнгээр мэдээлээгүй байна.

Хугацаа хоцроож мэдээлсэн байгууллагуудын хувьд 1-108 удаагийн мэдээлэл хоцорсон төлөвтэй байгаа бөгөөд энэ нь зарим байгууллагуудын хувьд шилэн дансны цэс шинээр нээлгэснээс нөхөж мэдээлэл байршуулсан, мөн батлагдсан төсөв өөрчлөгдөхөд өмнөх мэдээллийг засварласантай холбоотой байна.

Эдгээр нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэснийг зөрчжээ.

Иймд зөрчил гаргасан дээрх байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудад хуулийн дагуу хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.4. Шилэн дансны тухай хуулийн 3.1.3-д хамаарах “Шивээ овоо” ХК нь хуулийн 6 дугаар зүйлийн 6.8-д заасан мэдээллийг нөхөн мэдээлснээс нийт оруулсан мэдээллийн 70.1 хувь нь хугацаа хоцорсон төлөвтэй байна.

“Шивээ-Овоо” ХК нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, Худалдан авах ажиллагааны тайлан, Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн мэдээллүүдийг нөхөн мэдээлсэн байна.

2016 оны 10 сараас 2017 оны 09 дүгээр сарын дуустал нийт 63 мэдээлэл оруулахаас 51 мэдээлэл оруулж, 12 мэдээллийг оруулаагүй байна. Тухайлбал, 2016

онд хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл, Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр, Их хэмжээнд тооцогдохуйц хэлцэлд гаргасан баталгаа, батлан даалтын мэдээлэл зэрэг 2016 оны мэдээллийг нөхөн оруулаагүй байна.

Эдгээр нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8-д “Энэ хуулийн 3.1.3-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.8.1-д “тухайн байгууллагад холбогдох энэ хуулийн 3.2.5, 3.2.7, 3.2.8-д заасан шийдвэр”, 6.8.2-т “худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчдод тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан”, 6.8.3-т “төр болон орон нутаг тавь буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа компанийн гаргасан их хэмжээний хэлцэлд тооцогдохуйц баталгаа, батлан даалт” гэснийг тус тус зөрчсөн байна.

“Шивээ-овоо” ХК-д холбогдох мэдээллийг хугацаанд нь оруулж байх зөвлөмж, хугацаа хоцроосон албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

2.5. Шилэн дансны тухай хуулийн 3.1.5-д хамаарах хувийн цэцэрлэгүүд нь хуулийн 6 дугаар зүйлийн 6.9-д заасан мэдээллийг байршуулсан байна.

Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газраас 4 хувийн цэцэрлэгт санхүүжилт хуваарилдаг бөгөөд эдгээр цэцэрлэгүүд нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цэс нээлгэсэн бөгөөд холбогдох мэдээллийг тухай бүр байршуулсан байна.

Нийт 16 мэдээлэл байршуулахаас 15 мэдээлэл байршуулсан бөгөөд үүний 9 буюу 60.0 хувь нь хугацаа хоцорсон төлөвтэй, 1 мэдээллийг огт байршуулаагүй байна.

Бүлэг 3

Төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй байна.

3.1. Аймаг, сумдын ИТХ, багийн ИНХ-аас хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аймаг, сумдын ИТХ болон багийн ИНХ-аас хуулийн дагуу хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй бөгөөд аудитын явцад хийсэн ажлын тайлан, холбогдох мэдээллийг гаргаж ирүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал, төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ” гэснийг мөрдөж ажиллаагүй байна.

Иймд уг хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах чиг үүрэг бүхий байгууллагууд хуулиар олгогдсон чиг үүргээ хэрэгжүүлж, гарсан алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

3.2. Хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасан этгээд хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ гэж хуульчилсны дагуу аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцын 78 байгууллагад 2017 оны 3 дугаар улиралд дотоод аудитын хяналтыг тавьж ажилласан байна.

Санхүүгийн хяналт, аудитын алба нь аймгийн ТЕЗ-ийн хүрээний төсвийн байгууллагууд, ОНӨҮГ-уудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2017 онд сар бүр хяналт тавьж, тайланг аймгийн Засаг дарга, аймгийн ЗДТГ, Санхүү, төрийн сангийн хэлтэст тус тус тайлагнаж, мэдээллийн самбар гарган дүгнэжээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын 59 байгууллагыг хамруулсан бөгөөд холбогдох байгууллагуудад албан тоот хүргүүлж, хуулийн хэрэгжилтийн тайлан,

мэдээг Төсвийн Ерөнхийлөн захирагч болон Сангийн Яаманд улирал бүр хүргүүлжээ.

Хяналт шалгалтаар 55 байгууллагын мэдээлэл дутуу болон зөрүүтэй байсныг залруулж, хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар 36 байгууллагад давхардсан тоогоор 55 албан бичиг хүргүүлж, 14 байгууллагын Шилэн данс хариуцсан ажилтанд хариуцлага тооцуулахаар албан шаардлага өгсөн байна.

ШОХК, “Шивээ Сервис” ХХК, Автотээврийн үндэсний төв дээрх хяналт шалгалтад хамрагдаагүй байна.

Санхүүгийн хяналт, аудитын албаны хийсэн шалгалтаар байгууллагууд шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаа хоцроож мэдээлсэн, мэдээллээ дутуу буюу буруу байршуулсан, давхардуулсан, алдаатай оруулсан зэрэг зөрчил нь аудитаар давтан гарч байгаа нь байгууллагуудын дотоод хяналт хангалтгүй байгааг харуулж байна.

3.3. Хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т заасны дагуу үр дүнгийн гэрээнд хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай тусгасан байна.

Төсвийн захирагч нарын үр дүнгийн гэрээнд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай тусгаж ажилласан байна.

3.4. Хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу аймгийн хэмжээнд иргэдээс ямар нэгэн гомдол, мэдээлэл, хүсэлт ирүүлээгүй байна.

Аудитын явцад иргэдээс шилэн дансны мэдээлэлтэй холбоотой ямар нэгэн гомдол, мэдээлэл, хүсэлт ирүүлээгүй байна.

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх

Бүлэг 4

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

4.1. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажилласан байна.

Өмнөх аудитаар аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанд зөрчил гаргасан байгууллагуудын зөрчлийг арилгуулж, хуулийн хэрэгжилтийг хангуулах 1 албан шаардлага өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

4.2. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжилт 100.0 хувьтай байна.

Өмнөх аудитаар аймгийн Засаг дарга болон Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга нарт хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөвлөмжийн дагуу Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж ажилласан байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1, 3.2-т заасан байгууллагуудаас нийт 8 байгууллага, сан шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цэс нээлгээгүй байна.
2. Шилэн дансны мэдээллийг дутуу байршуулсан, байршуулсан нийт мэдээллийн 33% нь хугацаа хоцорсон төлөвтэй байна.
3. Шилэн дансны тухай хуулийн 3.1.3-д хамаарах “Шивээ овоо” ХК нь хуулийн 6 дугаар зүйлийн 6.8-д заасан мэдээллийг нөхөн мэдээлснээс нийт оруулсан мэдээллийн 70.1 хувь нь хугацаа хоцорсон төлөвтэй байна.
4. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй байна.
5. Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан хөндлөнгийн хяналтыг бүх шатны ИТХ хэрэгжүүлж ажиллаагүй байна.
6. Хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасан этгээд хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.
7. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Аудитаар нийт 524.3 сая төгрөгийн зөрчил илрүүлж, зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлагыг 54 байгууллагын холбогдох албан тушаалтнуудад хүргүүллээ.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараахь зөвлөмжийг өгч байна.

Бүх шатны ИТХ-ын дарга нарт:

1. Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу хяналт тавих эрхээ хэрэгжүүлэн ажиллах

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга Н.Алтанцэцэг танаа:

1. Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, үйл ажиллагааны явцад дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллах, дотоод хяналтын тайланг холбогдох албан тушаалтанд тайлагнах,
2. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, алдаа зөрчлийг давтан гаргасан төсвийн захирагч нарт хариуцлага тооцуулах саналаа эрх бүхий албан тушаалтанд тухай бүр хүргүүлж байх
3. Мэдээллээ дутуу буюу буруу байршуулсан байгууллагуудын алдаа зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх, аймгийн хэмжээнд “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтийг хангаж, шилэн дансны мэдээлэл хариуцсан албан хаагчдыг нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл оруулах, маягт бөглөх талаарх зааварчилгаа өгөх, нэгдсэн нэг ойлголттой болгох арга хэмжээг зохион байгуулах,
4. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нээсэн илүү цэсийг хасуулах,
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх тал дээр анхаарч ажиллах

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас ирүүлсэн санал:

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДГЭХ
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН
АЛБА

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг,
Нутгийн удирдлагын ордон 305 тоот,
E-mail: sankhuu_audit_ga@yahoo.com

2014.11.15 № 85
танай 2014.11.14-ны № 131 -т

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Танай байгууллагаас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хийсэн Нийцлийн аудитын тайлантай танилцлаа.

Уг тайланд манай байгууллагыг 2017 онд 5 удаа хэсэгчилсэн шалгалт хийсэн, 3 дугаар улиралд хяналт тавьж ажилласан гэж бичжээ.

Манай байгууллага нь Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу аймгийн төсвийн байгууллагууд, ОНӨҮГ-уудын шилэн дансны хуулийн хэрэгжилтэнд сар бүр тогтмол хяналтыг тавьж ажилладаг бөгөөд тайланг сар бүрийн 15-ны дотор аймгийн Засаг дарга, аймгийн ЗДТГ-ын дарга, аймгийн СТСХ-ийн дарга нарт тайлагнадаг.

Мөн байгууллагуудын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг сар бүр дүгнэн ханын самбартаа тэмдэглэн нийтэд үзүүлдэг болно.

ДАРГА



НАЛТАНЦЭЦЭГ

Т. Ногонбол
Саналыг тайланг
үсрээх
2014.11.14

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ХИЙСЭН ТАЙЛБАР

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас ирүүлсэн албан бичигтэй танилцаад ажлын тайлагналын талаар засварласан болно.

ҮАГ-ЫН НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗАРТ УЛАМЖЛАХ САНАЛ:

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуулийн заалт бүрээр цэсийг ойлгомжтой болгох, холбогдох мэдээллүүдийг оруулсан огноо харагддаг байх нөхцлийг бүрдүүлэх зэргээр нэгдсэн цахим хуудсыг илүү боловсронгуй болгох

2. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл байршуулах эсэх нь тодорхойгүй зарим сан, байгууллага, мөн толгой компани, байгууллагууд дээрээ мэдээлэл нь нэгдсэн журмаар байрших салбар байгууллагуудын жагсаалтыг орон нутагт ирүүлэх, эсвэл журмаар зохицуулан тодорхой болгох